

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ “ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар/

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	Арга хэмжээний дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн эх үүсвэр)		Хэрэгжилтийн хувь
						2022 он		
						Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
1	2	3	4	5	6	7	8	9
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО								
3.1. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.								
3.1.10. Гадаад худалдааг дэмжсэн гаалийн үйлчилгээг хялбаршуулж, иргэдийг хууль бус, хуурамч бараанаас сэргийлэх, байгалийн баялгаас татварыг бүрэн хураахад чиглэсэн гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.		Барааны борлуулалтын шат дамжлага бүрийг бараа бүртгэлийн нэгдсэн системээр дамжуулан бүртгэж, иргэд гар утасны "и-баримт" аппликейшн ашиглан тамхи, согтууруулах ундаа зэрэг онцгой албан татвартай бүх төрлийн бараа, эмийн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар зэрэгт хяналт тавих боломжийг	2020-2024	Сангийн яам Хамтрагч Гаалийн ерөнхий газар		Татварын ерөнхий газрын ач холбогдолтой барааг Бараа бүтээгдэхүүний нэгдсэн системээр дамжуулан бүртгэсэн байна.	Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар болон Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв хамтран татварын удирдлагын нэгдсэн систем болон гаалийн мэдээллийн системийг харилцан уялдуулж, экспорт, импортын бараа бүтээгдэхүүний мэдээллийг цахим хэлбэрээр солилцох “Бараа бүртгэлийн нэгдсэн систем /ББНС/”-ийг 2020 оны 04 сарын 01-ны өдөр нэвтрүүлсэн. Гаалийн байгууллагаас лабораторийн дүгнэлт бичих болон гаалийн мэдүүлэг нөхөн бичих үед барааны мэдээлэлд баркод (GS1-13 зураасан код) –ыг бичиж, экспорт, импортын мэдүүлгийг ББНС-рүү илгээж байна. Тайлан хугацаанд Бараа бүртгэлийн нэгдсэн системтэй холбоотой дараах хөгжүүлэлтийг хийж, нэвтрүүлсэн. - Мэдээлэл солилцож буй сервист мэдүүлгийн төлөв, ангиллын тоо хэмжээ, хэмжих нэгж талбарыг нэмсэн. - Мэдүүлгийг өдөрт нэг удаа бөөнд нь илгээдэг байсныг өөрчилж гааль зөвшөөрөх үед илгээдэг болгосон.	80

		бүрдүүлнэ.					<p>- Засгийн 362-р тогтоолын хэрэгжилт, гэрээ бүртгэлийн програмын хөгжүүлэлттэй холбоотойгоор гадаад худалдааны гэрээний дугаар, барааны дугаар талбаруудыг нэмсэн.</p> <p>- Гаалийн байгууллага дээж бүртгэх, лабораторийн дүгнэлт бичихдээ гэрээг нь ГТСМТТ УҮГ-с тэдний системээс цахимаар татаж оруулдаг болгосон. Одоогоор и баримтын систем рүү орох болон бүх гэрээг харах эрх байхгүй байна. Тайлант хугацаанд Гаалийн экспорт, импортын мэдүүлгийн мэдээллийг Бараа бүртгэлийн нэгдсэн систем рүү баркодтой 857,962, баркодгүй 1,272,000 барааны мэдээлэл илгээсэн. GS-13-1 буюу баркодыг цэгцлэн, баркодыг үнэн зөв оруулж, барааны урсгалын хянах талаар "Монголын GS нийгэмлэг"-тэй уулзалтыг хийсэн. Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв УҮГ-тай БНС-н талаар уулзалт хийж, БНС-д хандах болон аналитик тайлангийн системд хандах эрхийг 7-н албан хаагчдад авсан байна. Эдгээр албан хаагчдын холбогдох мэдээллийг УҮГ-т явуулсан. Одоогоор эрх нь ирээгүй байна. Энэ эрхийг авснаар гаалийн мэдүүлэгт бичиж байгаа баркод татварын бараа бүртгэлийн системд хэрхэн харагдаж байгаа болон гаалийн хяналтад ашиглах боломжтой эсэхийг харах зорилготой юм.</p>	
3.1.17.Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг	3	“Алтанбулаг” чөлөөт бүсийг Гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбоно.	2022-2024	Шадар сайдын ажлын алба, Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба Хамтрагч		Төслийг хэрэгжүүлж эхэлнэ.	Гаалийн ерөнхий газраас болон Сэлэнгэ аймаг дахь гаалийн газраас Алтанбулаг чөлөөт бүсийн ажлын алба, Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд 2019 онд 27, 2020 онд 6, 2021 онд 14 буюу нийт 47 удаагийн албан бичгээр теле хяналтын камер тавих, гаалийн байгууллагатай нэгдсэн системд холбогдох, архи, согтууруулах ундааг худалдан борлуулах хуульд заасан шаардлагыг мөрдүүлэх зэрэг асуудлаар хандсан байна.	

<p>бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана.</p>				<p>Гаалийн ерөнхий газар</p>			<p>Чөлөөт бүсийн камерыг гаалийн нэгдсэн системд холбуулах ажлын хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас гаалийн байгууллагад дараах тайлбарыг ирүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний “Засаглалын бодлого”-ын “Алтанбулаг чөлөөт бүсийг гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбох” хэсэгт шилэн кабелийн зардлыг тусгаж оруулсан боловч төсөвт суугдаагүй; • Чөлөөт бүсийн дэд бүтцийн барилга байгууламжуудын ажлын улсын төсвийн хөрөнгө оруулалт зогсож, сүүлийн 8 жилд хөрөнгө оруулалтын зардал огт тавигдаагүй. 2016 оноос эхлэн төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлсэн. • Өнөөдрийн байдлаар Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанаас 2022 оны төсвийн төсөөлөлд саналаа хүргүүлсэн боловч батлагдаагүй учраас 2023 онд “genetic system”-ийн үнийн саналыг дахин судалж, шинэчлэн хүргүүлсэн болно. <p>Дүгнэлт: Алтанбулаг чөлөөт бүс гаалийн телехяналтын нэгдсэн системд холбогдоогүй байна. Гаалийн байгууллагаас үл шалтгаалах төсвийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалж, уг ажил хойшлогдож байна.</p> <p>/үнэлүүлэхгүй/</p>	
<p>3.1.18.Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, хөрш орнуудын хилийн боомтуудын жишигт хүргэнэ. Хилийн заставуудын барилга, объектуудыг шинэчилж чанарыг</p>	<p>1</p>	<p>Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж сайжруулна.</p>	<p>2021-2024</p>	<p>Сангийн яам Хамтрагч Гаалийн ерөнхий газар</p>		<p>Гашуунсухайт, Бичигт, Шивээхүрэн боомтуудын бүтээн байгуулалтын ажилтай зэрэгцүүлэн гаалийн хяналт шалгалт болон салбар</p>	<p>Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 362 дугаар тогтоолын 1.3 дахь хэсэгт “Гаалийн автомат бүрдүүлэлтийн систем, ухаалаг гарцын байгууламж, нүүрсний шинжилгээний лабораторийг Шивээхүрэн боомтод 2022 онд, Гашуунсухайт, Замын-Үүд боомтод 2023 оны 3 дугаар улиралд, Ханги, Булган, Бичигт боомтод 2024 оны 2 дугаар улиралд тус тус багтаан ашиглалтад оруулах” гэж заасан.</p>	

сайжруулна.						<p>лабораторийн тоног төхөөрөмжийг суурилуулж, иж бүрэн сайжруулж, хилээр нэвтэрч буй уул уурхай, эрдэс бүтээгдэхүүнээс дээж авч шинжлэн, татварыг бүрэн ногдуулах нөхцөл бүрдсэн байна.</p>	<p><u>Шивээхүрэн боомт:</u> Шивээхүрэн боомтод ухаалаг гарцын байгууламжийн тоног төхөөрөмж суурилуулах ажил бүрэн дууссан. Мөн суурилуулсан тоног төхөөрөмж болон ухаалаг гарцын системийг гаалийн хяналт бүрдүүлэлтийн КАИС системтэй холбон туршилтын ажлыг хийж нэвтрүүлэхэд бэлэн байдлыг хангасан. Зураг төсөл: 100% Дэд бүтэц: 100% Тоног төхөөрөмжийн суурилуулалт: 100% Програм хангамжийн гүйцэтгэл:98% /ухаалаг гарцын систем, тоног төхөөрөмжийг бодит орчин нэвтрүүлэх ажиллах явцад програм хангамжийн зарим өөрчлөлт гарах тул тухай бүр засвар өөрчлөлтийг хийж ажиллахаар төлөвлөж байна.</p> <p><u>Гашуунсухайт боомт:</u> Гаалийн ерөнхий газрын даргын удирдамжаар 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрүүдэд Гашуунсухайт хилийн боомтод ажилласан ажлын хэсэг тус боомтын Нүүрс тээврийн хэсэгт Ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг түр суурилуулах байршлуудыг тогтоож, гүйцэтгэгч Мэйжүрмэнт ХХК-д гаргаж өгөөд байна. Мөн ажлын хэсгээс хөрөнгө оруулалт нь шийдэгдээгүй байгаа Алтанбулаг, Бичигт, Боршоо боомтуудад байрших тоног төхөөрөмжийн тооцооллыг урьдчилсан байдлаар гарган АХБ-д хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх хүсэлт тавин ажиллаж байна. Автозамын хилийн боомтуудад тээврийн хэрэгсэлд ачигдсан нүүрснээс дээж авч, нүүрсний үнслэг, чийглэг, илчлэг болон хэмжигдэхүйц химийн элементийн агууламжийг автоматаар тодорхойлох 7 ширхэг (AUSTRIA төхөөрөмж+TEXAS төхөөрөмж) дээж авагчийг Гашуунсухайт, Булган, Ханги, Шивээхүрэн, Бичигт, Цагаандэл-Уул боомтод, тээврийн хэрэгсэлд</p>	70
-------------	--	--	--	--	--	--	---	----

						<p>ачигдсан бараанд нуусан эд зүйлийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний явцад илрүүлэх хүчин чадалтай 14 ширхэг рентгенийг автозамын хилийн 11 боомтод суурилуулахаар төлөвлөн ажиллаж байна. Эхний 1 иж бүрдэл рентген төхөөрөмж Шивээхүрэн боомтод суурилагдан туршилт явуулсан.</p> <p>2022 оны 05 дугаар сарын 11-ны ОХУ-ын нийлүүлэгч компаниас мэргэжилтнүүд ирж, Шивээхүрэн боомтод суурилуулсан рентгенийг гаалийн байгууллагад хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.</p> <p>Гаалийн шинэчлэлийн хүрээнд байгуулсан Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар - Цагаан нуур, Сайншанд дахь гаалийн газар, Орхон аймаг дахь гаалийн газар, Гашуунсухайт дахь гаалийн газар-ОТ, Дорнод аймаг дахь гаалийн газрын Баянхошуу боомтуудын салбар лабораториудад нийт 90 шинжилгээний тоног төхөөрөмжүүдийг суурилуулж, бүрэн ашиглалтад оруулснаар 2022 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар нийт 2171 дээжид магадлан шинжилгээг хийж, 1861 дүгнэлт гаргаж шинжилгээний хураамжаар 197,477 сая төгрөгийг улсын төсөвт оруулсан.</p> <p>Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Сайншанд дахь гаалийн газар, Орхон аймаг дахь гаалийн газар , Гашуунсухайт дахь гаалийн газар -ОТ, Дорнод аймаг дахь гаалийн газрын Баянхошуу боомтын салбар лабораториудын ашиглалтад бүрэн оруулснаар нийт 2171 дээжинд магадлан шинжилгээг хийж, 1861 дүгнэлт гаргасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дээрх салбар лабораториудын шинжилгээнд хамрагдсан дээжний тоо 243,7 %-иар нэмэгдэж, тухайн гаалийн газраас магадлан шинжилгээнд хамруулах хугацааг 2-3 хоногоор бууруулж ажилласан. Үүний үр дүнд татварыг бүрэн авах боломжийг</p>	
--	--	--	--	--	--	---	--

						<p>бүрдүүлсэн.</p> <p>Хэдийгээр тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулж, ашиглалтад оруулсан ч лабораторийн агааржуулалт муу байгаагаас болон хүний нөөцийн дутагдалтай байдлаас шалтгаалан зарим шинжилгээг иж бүрэн хийх боломжгүй байна.</p> <p>2022 онд Гаалийн ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар Гаалийн байгууллага хилийн мэргэжлийн хорио цээрийн байгууллага нэгдсэнтэй холбогдуулан Гаалийн төв лаборатори болон Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын Цагаан нуур боомт, Ховд аймгийн Булган дахь гаалийн газрын Булган боомт, Дорнод аймаг дахь гаалийн газрын Баянхошуу боомт, Увс аймаг дахь гаалийн газрын Боршоо, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын салбар лабораториудад 1,591 тэрбум төгрөгийн өртөг бүхий 133 хорио цээр, эрүүл ахуйн шинжилгээний тоног төхөөрөмжийг нийлүүлснээр шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлээд байна.</p> <p>2022 онд Боомтын бүтээн байгуулалттай холбогдуулан АХБ-ын санхүүжилтээр Увс аймаг дахь гаалийн газрын Боршоо боомтод нефтийн бүтээгдэхүүн, хорио цээр, эрүүл ахуйн шинжилгээ хийх хүчин чадал бүхий лабораторийн барилгыг ашиглалтад оруулж, нефтийн 12 тоног төхөөрөмж, хорио цээрийн 22 тоног төхөөрөмжийг нийлүүлээд байна.</p> <p>Мөн Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын салбар лабораторийг улсын төсвийн хөрөнгөөр байгуулж, химийн болон хар тамхи, мансууруулах бодис шинжлэх зориулалттай 4 тоног төхөөрөмж, хорио цээр, эрүүл ахуйн 22 тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.</p> <p>Тайлбар: Гашуунсухайт, Бичигт, Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай, салбар лабораторийн үйл ажиллагаа нь тодорхой үр дүнд хүрсэн байна.</p>	
--	--	--	--	--	--	--	--

3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.								
3.7.14.Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж “Замын-Үүд” чөлөөт бүсийг байнгын үйл ажиллагаанд оруулна.	1	“Замын-Үүд” чөлөөт бүсийг нээж, байнгын ажиллагаанд оруулна.	2021	Шадар сайдын ажлын алба Оролцогч Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар		-	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 223 дугаар тогтоолоор “Замын-Үүд” чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлэх тухай шийдвэр гарсан. Чөлөөт бүсийн үйл ажиллагааны гол зорилго нь бизнесийн таатай орчинг бүрдүүлэн хөрөнгө оруулагчдыг татах замаар гадаад худалдааг дэмжиж улсынхаа эдийн засгийг нэмэгдүүлэхэд оршино. Замын-Үүд чөлөөт бүс байнгын үйл ажиллагаанд орсноос хойш бүсэд 5 татваргүй барааны дэлгүүр, “Эрмос констракшн” ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 2022 оны байдлаар 81 Аж ахуйн нэгжийн 88 төсөл хэрэгжихээр Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанаас холбогдох зөвшөөрлөө авсан байна. Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй 5 дэлгүүр нь GS1 баркод системээр гаалийн байгууллагын автоматжуулсан мэдээллийн системд холбогдон мэдээллийг цахимаар солилцож байна. Уг систем нь чөлөөт бүсээс зорчигчийн худалдан авсан тарифын бус хязгаарлалттай бараа (согтууруулах ундаа, тамхины бүтээгдэхүүн)-г зөвшөөрөгдсөн тоо хэмжээгээр гаалийн болон бусад татваргүйгээр хоногт 1 удаа худалдан авахад бүрэн хяналт тавьдаг. Замын-Үүд чөлөөт бүс байнгын үйл ажиллагаанд шилжсэнээс хойш 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 82,154 зорчигч, 18,174 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн байна. 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Замын-Үүд чөлөөт бүсэд дараах гаалийн бүрдүүлэлтүүд хийгдсэн байна. (Оны эхнээс өссөн дүнгээр) Үүнд:	100

						<p>/770/ “Гадаадын барааг чөлөөт бүсэд оруулах” горимоор “Эмон чөлөөт бүс” ХХК, “Эс Эп Ти чөлөөт бүс” ХХК, “Алтайн ундрах шанд чөлөөт бүс” ХХК, “Солонго инвест чөлөөт бүс” ХХК, “Ти Ар монголиа чөлөөт бүс” ХХК, “Домогт туул чөлөөт бүс” ХХК, “Эморс констракшн чөлөөт бүс” ХХК гэсэн Аж ахуйн нэгжүүдийн 24 мэдүүлгээр 1,176,203.71 ам доллар,</p> <p>/778/ “Гаалийн бусад хяналтаас чөлөөт бүсэд оруулах” горимоор “Эс Пи Ти” ХХК-ийн 1 мэдүүлгээр 145,488 ам доллар,</p> <p>/773/ “Монголын барааг гаалийн нутаг дэвсгэрээс оруулах” горимоор “Жинхунруй” ГХО ХХК, “МАК Цемент” ХХК, “Клаймакс-Интернэшнл” ХХК, “МЦЦТ” ХХК, “Акмырза” ХХК, “Нэйшнл бест конкрет” ХХК, “Мара мина” ХХК- “Бандайхийц” ХХК, “Стандарт-Оюу” ХХК, “Талын торгон зам” ХХК болон 3 иргэний 224 мэдүүлгээр 595,551.753 ам доллар статистик үнийн дүнтэй бараа /барилгын бүтээн байгуулалтын шинжтэй/ тус тус оруулсан бол</p> <p>/460/ “Чөлөөт бүсээс чөлөөт эргэлтэд оруулах”-11 автомашин,</p> <p>/640/ “Чөлөөт бүсийн горимд байршуулсан монголын барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах” горимоор-18 мэдүүлгээр 53712.118ам долларын бүрдүүлэлт хийгдсэн байна.</p> <p>2022 оны байдлаар 81 ААН-ийн 88 төсөл хэрэгжихээр Замын–Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанаас холбогдох зөвшөөрлөө авсан байна.</p> <p>Гаалийн байгууллага нь Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/282 дугаар тушаалын хавсралтаар “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”-ын дагуу чөлөөт бүсийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг.</p> <p>Монгол улсын засгийн газар, Бүгд найрамдах хятад ард улсын засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Засгийн газрын 2022 оны 280 дугаар тогтоолоор</p>
--	--	--	--	--	--	---

							Хамтын ажиллагааны бүсийн Хамтарсан зохицуулах зөвлөлийн Монголын талын бүрэлдэхүүнийг баталсан байна. Тайлбар: Тодорхой хэмжээнд үр дүн гарч байгаа боловч, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай	
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО								
4.3. Амар тайван, аюулгүй нийгэм. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.								
4.3.13.Иргэдийн эрүүл бүтээгдэхүүн хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтүүдийг өндөр нарийвчлалтай тодорхойлж, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрсдэлд суурилсан хяналтаар чанд мөрдүүлнэ.	1	Хилийн боомт дахь улсын байцаагчдыг хүнсний бараа, бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох түргэвчилсэн багаж хэрэгслээр хангаж, эрсдэл өндөртэй бараа, бүтээгдэхүүний илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.	2020-2024	Шадар сайдын ажлын алба, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори Хамтрагч Сангийн яам		-	1.Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын арга хэрэгслийг сайжруулах нь” МОН 3310 төслийн хүрээнд Замын-Үүд дэх гаалийн газар болон Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын салбар лабораторид тус бүр 397 723 000 төгрөгийн өртөг бүхий хүнсний бараа, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох дараах лабораторийн тоног төхөөрөмжүүдийг 2022 оны 2 дугаар сард нийлүүлсэн. Үүнд: -Атом шингээлтийн спектрометр 240FS with GTA120 & PSD120-хүнд металл тодорхойлох, -Газ хроматографи /масс спектрофотометр 5977B MSD Bundle with 8860 GC-пестицидийн үлдэгдэл тодорхойлох, -Шингэний хроматографи 1260 Infinity II-хүнсний нэмэлт тодорхойлох, -FTIR спектрометр Alpha II, Үр тарианы цавуулаг ба чийг хэмжигч багаж Perton NIR9500 үр тарианд чийг, уураг, тос, цавуулаг, цардуул, эслэг, үнслэг тодорхойлох, -Хүнсний микробиологийн анализатор Vidas-E.coli, Salmonella, L.monocytogenes, S.enterotoxin, campylobacter илрүүлэх тоног төхөөрөмжүүд. Дээрх боомтууд дахь гаалийн хорио цээрийн лабораторийн шинэ барилгын ажлын гүйцэтгэл 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 95 хувьтай байна. Гаалийн хорио цээрийн хяналтад хамрагдах бараанаас БТКУС-ын 8 орны түвшний 230 барааг хасаж, 2502 барааг өндөр, дунд, бага эрсдэлээр ангилан Кайсын цахим системд	100

						<p>оруулж, хяналт хийгдсэн.</p> <p>Хяналтад хамруулсан тухай мэдэгдлийг олгохгүй болж хяналт шалгалтын үр дүнг программд бичиж оруулдаг болсон.</p> <p>Бараа, бүтээгдэхүүнээс дээж авсан тэмдэглэл, бараа, бүтээгдэхүүний дээжийг лабораторид өгсөн тэмдэглэлийг үйлдэхийг зогсоож, магадлан шинжилгээ хийлгэх шийдвэр бичиж эхэлсэн</p> <p>Хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчийг CAIS системээс 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс томилж эхэлснээс хойш импортын 48587, экспортын 4803 мэдүүлгийн бараанд хяналт шалгалт хийж 144 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 15 зөрчилд зөрчлийн хэрэг бүртгэл явуулж, 3 зөрчлийн хуулийн байгууллагад шилжүүлсэн.</p> <p>Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 109 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсэг гаалийн хорио цээрийн хяналтыг цахимжуулах 14 модулийн ажлын даалгаврыг боловсруулж, энэ хүрээнд өндөр эрсдэлтэй хүнсний бараанд импортын мэдэгдлийг цахимаар олгон хяналт, шалгалтыг хийж, хүн, мал, амьтан, ургамлын эрүүл мэндэд шууд нөлөөлж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан.</p>	
2	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох чадварыг нэмэгдүүлж, Хүнсний аюулгүй байдлыг хангуулна.		Мэргэжлийн хяналтын ерөнхий газар		-	<p>Гаалийн тухай хуулийн 269 дүгээр зүйлд 2021 оны 11 сарын 21-ний өдөр нэмэлт орж, улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх чиг үүрэг гаалийн байгууллагад шилжин ирснээр Гаалийн хорио цээрийн газраас импорт, экспортын хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд хяналтыг тавьж байна.</p> <p>Засгийн газрын 2022 оны 04, 05 дугаар тогтоол, Сангийн сайдын 2022 оны 02 дугаар тушаалаар гаалийн хорио цээрийн хяналтыг хэрэгжүүлэх бүтэц орон тоо шилжин, ГЕГ-ын бүтцэд шинээр “Гаалийн</p>	100

						<p>хорио цээрийн газар” гэсэн нэгж байгуулагдаж, ГЕГ-ын даргын 2022 оны А/19 тоот тушаалаар “Улсын хилээр нэвтрүүлэх зорчигч, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт хэрэгжүүлэх түр заавар”-ыг, ГЕГ-ын 2022 оны А/34 дүгээр тушаалаар Гаалийн хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах барааны 32 хяналтын хуудсыг батлуулан, мөрдүүлж, үүнээс 6 хяналтын хуудсыг импорт, экспортын хүнсний бүтээгдэхүүнийг хянахад ашиглаж байна.</p> <p>Гаалийн газар, хороодоос хорио цээрийн импортын хяналт, шалгалтад хамруулсан хүнсний бараа, бүтээгдэхүүнийг лабораторийн шинжилгээнд хамруулсан мэдээг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгон гаргахад нийт 12598672.8 тн, 1467560 ширхэг, 54 хайрцаг бараа, бүтээгдэхүүнээс 9298 удаагийн дээж авалтаар 75687.8 кг, 8172 ширхэг, 64.1 литр, дээжийг хими, нян судлал, эмийн үлдэгдэл, хор судлал, хүнд металл, цацрагийн бохирдол, ургамлын хорио цээрийн шинжилгээнд хамруулахад шаардлага хангасан 54852 бараа, шаардлага хангаагүй үзүүлэлт 128 барааг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж, 471.041.632 төгрөгийг Төрийн санд байршуулж ажилласан байна.</p> <p>Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 20 дугаар тушаалаар гаалийн лаборатори, хорио цээрийн лабораторийн үйл ажиллагааг уялдуулан, хилийн боомт дахь хорио цээр, эрүүл ахуйн лабораторийг нэгтгэх, дээж авах давхардлыг арилгах, цахимжуулах асуудлаар судалгаа хийж ажилласан.</p> <p>Энэ ажлын хүрээнд Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур, Булган боомтын 4 лабораторийг нэгтгэхээр багаж, төхөөрөмжийн судалгаа, техникийн үзүүлэлт, итгэмжлэлийн хүрээг</p>
--	--	--	--	--	--	---

						<p>тодорхойлсон. Хорио цээрийн шинжилгээ хийх лабораторийн нэрс, шинжилгээний үзүүлэлтүүдийг CAIS програмд оруулж, “Дээж төлөвлөх, магадлан шинжилгээний шийдвэрийг цахимаар гүйцэтгэх түр заавар”-ыг боловсруулж, энэ чиглэлээр 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр газар, хороодын 100 гаруй гаалийн улсын байцаагч, шинжээчдийг оролцуулан сургалт зохион байгуулсан.</p> <p>Хилийн мэргэжлийн хяналтын чиг үүрэг гаалийн байгууллагад шилжсэнтэй холбогдуулан Гаалийн төв лаборатори, Ховд аймгийн Булган дахь гаалийн газрын Булган боомт, Дорнод аймаг дахь гаалийн газрын Баянхошуу боомт, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын Цагааннуур боомтын салбар лабораториуд болон шинээр байгуулагдаж байгаа Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын салбар лаборатори, Увс аймаг дахь гаалийн газрын Боршоо боомтын салбар лабораториудад хүнсний эрүүл ахуй, хорио цээрийн шинжилгээний чиглэлээр тоног төхөөрөмж нийлүүлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, 133 ш тоног төхөөрөмжийн захиалга хийгдсэн.</p> <p>Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 30 дугаар тушаалын дагуу импорт, экспортын хүнсний бүтээгдэхүүний стандартыг хянаж, шинэчлэн боловсруулах 122 стандартын жагсаалтыг гарган, СХЗГ-г хүргүүлсэн.</p> <p>Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/212 дугаартай "Хүнсний тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж, холбогдох саналыг өгч ажилласан.</p> <p>“Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрх зүйн орчин, чанар, аюулгүй байдлын хяналт” сэдэвт танхим, цахим хэлбэр хосолсон сургалтыг 2022 оны 4 сард зохион байгуулж, газар, хороодын</p>	
--	--	--	--	--	--	--	--

							200 гаалийн улсын байцаагчийг хамруулсан.	
4.4. Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хууль ёсыг бэхжүүлнэ.								
4.4.7. Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.	5	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ял хариуцлагыг нэмэгдүүлэх, мансуурах донтой этгээдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх, эрт шатанд нь илрүүлэх, эмчлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.	2021-2024	Хууль зүй, дотоод хэргийн яам Хамтрагч Гаалийн ерөнхий газар		Хуулийн төслийг боловсруулсан байна.	ХЗДХЯ-ны дэргэд байгуулагдсан Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, мансуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн хуралдаан 2021 оны 3 дугаар сард цахимаар зохион байгуулагдахад Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын Хар тамхины хяналтын албаны дарга Б.Сүхбаатар оролцсон. Хуулийн төсөлтэй тус газрын Хар тамхины хяналтын албаны албан хаагчид нэг бүрчлэн танилцаж, дараах саналыг төсөлд тусгуулахаар хүргүүлсэн. Үүнд: Санал №1. Төслийн 15 дугаар зүйл. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих талаар гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг 15.1.2. Шаардлагатай тохиолдолд зорчигч, тээврийн хэрэгсэл, бусдын дайсан ачаа тээш, бараа болон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай бодис, бүтээгдэхүүнд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх зорилгоор гаалийн хяналт, шалгалт, дахин шалгалт хийх гэж найруулах. Санал №2. 15.1 дэх хэсэгт 7, 8, 9 гэсэн заалтууд нэмж оруулах: 15.1.7. Сэжигтэй зорчигч, гаалийн харилцаанд оролцогч бусад этгээдийн талаар болон нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллийг цуглуулах, тэдгээрийн хилээр нэвтрэх хөдөлгөөнд хяналт тавих; 15.1.8. Гаалийн байгууллага нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх зорилгоор албаны эрэлч нохой сургах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн угтвар бодист анхан шатны болон нарийвчилсан	100

							<p>магадлан шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлж болно.</p> <p>15.1.9. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг, зөрчлийн талаар иргэдээс ирүүлсэн мэдээллийг хүлээн авах, шалгах;</p> <p>Санал №3. Төслийн 79 дүгээр зүйл. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих</p> <p>79.4. Цагдаа, тагнуул, /"гааль" гэж тусгайлан нэмж оруулах/ хил хяналтын болон холбогдох бусад байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн угтвар бодисын хууль бус эргэлтийг таслан зогсоох, энэ төрлийн зөрчил, гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.</p> <p>Санал №4. 80 дугаар зүйл. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилт</p> <p>Төслийн 80 дугаар зүйлд 80.31 заалт шинээр нэмэх:</p> <p>Энэ хуулийн төслийг 2023 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байгаа болно.</p>	
4.5. Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого. Монгол Улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн гадаад таатай орчныг улам бэхжүүлнэ.								
4.5.2.Эдийн засгийн гадаад харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх	3	Худалдаанд тулгарч байгаа хүндрэлийг багасгах зорилгоор гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн сан байгуулж, гадаад худалдаатай холбоотой бүх	2021-2024	Гадаад харилцааны яам Хамтрагч Гаалийн ерөнхий газар		Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх ерөнхий хэлэлцээрт нэгдэн орсноор худалдааны зардал буурах нөхцөл бүрдэнэ.	Дэлхийн банк группийн санхүүжилтээр ГХЯ болон Гаалийн ерөнхий газар хамтран Гадаад худалдааны мэдээллийн портал сайт хөгжүүлэн 2020 оны 12 сард ашиглалтад оруулсан ба гадаад худалдаатай холбоотой 500 орчим мэдээллийг тус сангаар түгээж нэг цэгээс мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн. Одоогийн байдлаар тус сангийн баталгаат засварын 5900\$-ийг Гаалийн ерөнхий газарт төлөвлөгдөөгүйн улмаас зогсонги байдалд байгаа бөгөөд төлбөрийн асуудлыг шийдвэрлэх эсхүл санг Цахим хөгжлийн	80

<p>бодлогыг үргэлжлүүлнэ.</p>		<p>мэдээллийг түргэн шуурхай, нэг цэгээс авах боломжийг бүрдүүлнэ. Цаасгүй худалдаа, цахим худалдааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр ажиллана.</p>					<p>яаманд шилжүүлэх боломжийг эрэлхийлэн 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн Худалдааг хөнгөвчлөх үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн. Одоогоор холбогдох шийд гараагүй байна.</p> <p>“Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр”-ийг УИХ-ын 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Чуулганаар батлуулахад дэмжлэг үзүүлсэн. Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНСУ-ын Засгийн газар болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хамтран ажиллаж, “Цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээ” хийх ажлыг 2022 оны 5 дугаар сард эхлүүлсэн.</p> <p>Үүнтэй уялдуулсан “Цахим худалдаа, түүний дотор худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл”-ийг 2022 оны 06 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд болсон уулзалтад Гаалийн ерөнхий газраас танилцуулсан.</p> <p>Тайланд Улсын Бангкок хотноо 2022 оны 12 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр”-ийн холбоо баригч нарын уулзалтад гаалийн байгууллагын өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулсан.</p> <p>Гаалийн ерөнхий газрын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгээс “Цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээ”-хийхтэй холбоотой “Төр, хувийн хэвшил, хэрэглэгч”-д зориулсан санал асуулгыг орчуулж, харилцагчдын матрицыг бэлтгэн ажилласан.</p> <p>НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурлын ажлын хэсэг 2023 оны эхний хагас жилд Монгол Улсад ажиллан эцсийн үнэлгээг гаргана.</p> <p>Энэ хүрээнд Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр 2023 оны 1</p>
-------------------------------	--	---	--	--	--	--	--

							<p>дүгээр сард төсөл эхлүүлэн, төслийн хүлээгдэж байгаа үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар уулзахаар төлөвлөсөн. Энэ талаар ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын гарын үсэгтэй албан бичгийг 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр ирүүлж, ажлын хэсэг байгуулан, хамтран ажиллах хугацаа, бусад асуудлыг зөвшилцөж байна.</p> <p>Тайлбар: Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч, өөрсдөөс хамаарах зохион байгуулалтын арга хэмжээ авагдсан</p>	
--	--	--	--	--	--	--	--	--

Дүгнэлт:

Гаалийн ерөнхий газрын 2022 оны “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” 2021-2024 онд хэрэгжих бөгөөд 2022 онд гүйцэтгэсэн ажлын дундаж үнэлгээ 88 хувьтай байна. Цаашид 2023, 2024 онуудад хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

---oO---